

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## **Агуулга**

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОТГОНСҮХ  
ТАНАА

2021.02.24 № 07/464  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,613,723.65</b>	<b>191,824,254.77</b>
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>149,613,723.65</b>	<b>191,824,254.77</b>
Бэлэн бүтээгдэхүүн	64,438,409.35	127,548,301.35
<b>Хангамжийн материал</b>	<b>85,175,314.30</b>	<b>64,275,953.42</b>
Бичиг хэргийн материал	34,604,187.00	11,839,035.00
Аж ахуйн материал	42,776,379.50	44,886,677.50
Сэлбэг хэрэгсэл	0.00	196,680.00
Түлш,шатах тослох материал	2,396,000.00	3,355,000.00
Бусад хангамжийн материал	5,398,747.80	3,998,560.92
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,760,051,006.96</b>	<b>7,092,127,768.89</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,760,051,006.96</b>	<b>7,092,127,768.89</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>8,663,436,636.96</b>	<b>6,972,749,455.89</b>
Барилга,байгууламж,орон сууц	5,440,864,311.00	5,440,864,311.00
Хуримтлагдсан элэгдэл	620,448,914.88	729,528,360.12
Авто-тээврийн хэрэгсэл	158,112,170.00	158,112,170.00
Хуримтлагдсан элэгдэл	102,730,225.63	119,162,170.00
Машин,тоног төхөөрөмж (компьютер)	7,442,894,908.96	7,644,569,976.17
Хуримтлагдсан элэгдэл	3,737,589,641.20	5,473,807,005.82
Тавилга, аж ахуйн эд хогшил	368,205,271.06	364,980,693.06
Хуримтлагдсан элэгдэл	296,537,908.83	321,946,824.84
Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	9,333,333.52	11,333,333.56
Биет бус хөрөнгө	96,614,370.00	119,378,313.00
Программ хангамж	3,530,000.00	3,530,000.00
Хуримтлагдсан элэгдэл	3,213,750.00	3,296,250.00
<b>Бусад биет бус хөрөнгө</b>	<b>96,298,120.00</b>	<b>119,144,563.00</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,909,664,730.61</b>	<b>7,283,952,023.66</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,909,664,730.61</b>	<b>7,283,952,023.66</b>
Засгийн газрын хувь оролцоо	6,849,976,358.38	6,849,976,358.38
Засгийн газрын оруулсан капитал	6,849,976,358.38	6,849,976,358.38
Хуримтлагдсан үр дүн	2,058,238,149.38	432,525,442.43
Өмнөх үеийн үр дүн	2,058,238,149.38	2,058,238,149.38
Тайлант үеийн үр дүн	-	-1,625,712,706.95
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,909,664,730.61</b>	<b>7,283,952,023.66</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,114,161,818.34	4,700,498,547.10
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,035,609,018.34	355,730,547.10
Нийтлэг татварын бус орлого	1,035,609,018.34	350,751,047.10
Төсөв байгууллагын өөрийн орлого	957,652,890.34	290,669,143.50
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	957,652,890.34	290,669,143.50
Түрээсийн орлого	77,956,128.00	60,081,903.60
Тусламжийн орлого	-	4,979,500.00
Хандив тусламж /дотоод	-	4,979,500.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,078,552,800.00	4,344,768,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	4,068,552,800.00	4,344,768,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,068,552,800.00	4,344,768,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,000,000.00	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,000,000.00	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,002,207,044.63	6,326,211,254.05
УРСГАЛ ЗАРДАЛ	3,779,220,764.59	3,916,570,308.38
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,913,187,128.67	6,169,554,419.58
ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,779,220,764.59	3,916,570,308.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,357,774,142.45	3,475,258,860.12
Үндсэн цалин	3,207,278,542.45	3,325,416,860.12
Унаа хоолны хөнгөлөлт	150,495,600.00	149,842,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	421,446,622.14	441,311,448.26
Тэтгэврийн даатгал	288,131,272.89	302,267,080.99
Тэтгэмжийн даатгал	26,663,070.33	28,233,198.48
ҮОМШӨ-ний даатгал	33,328,836.40	34,633,910.60
Ажилгүйдлийн даатгал	6,665,766.33	6,927,497.16
Эрүүл мэндийн даатгал	66,657,676.19	69,249,761.03
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,204,809.27	58,113,557.90
Гэрэл, цахилгаан	65,526,948.00	34,542,973.00
Түлш, халаалт	12,714,714.86	20,308,714.89
Цэвэр, бохир ус	3,963,146.41	3,261,870.01
Хангамж, бараа материалын зардал	41,439,724.26	45,001,053.84
Бичиг хэрэг	26,634,768.00	25,840,332.00
Тээвэр, шатахуун	9,628,600.00	7,692,000.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,793,563.26	2,916,123.84
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	779,500.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,602,793.00	7,773,098.00
Эд хогшил, урсгал засварын зардал	16,252,747.00	42,214,553.00
Багаж, техник, хэрэгсэл	-	378,200.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	9,110,450.00
Урсгал засвар	16,252,747.00	32,725,903.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,979,431.33	134,333,771.38
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,456,184.35	78,326,257.13
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	-
Даатгалын үйлчилгээ	2,287,743.00	2,336,868.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429,000.00	383,998.75
Газрын төлбөр	591,800.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	50,126,703.98	53,198,647.50
Бараа үйлчилгээний бусад зардал	1,907,089,652.22	1,973,321,175.08
Бараа үйлчилгээний бусад зардал	13,088,598.00	32,771,562.28
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,217,400.00	7,593,272.73

Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,887,783,654.22	1,932,956,340.07
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,019,915.96	156,656,834.47
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,019,915.96	156,656,834.47
Төвлөрүүлэх шилжүүлэг	89,019,915.96	156,656,834.47
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-888,045,226.29	-1,625,712,706.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,099,314.76	-
Үнэ төлбөргүй гарсан зардал	4,099,314.76	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-892,144,541.05	-1,625,712,706.95



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,156,508,928.00	4,411,566,784.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,956,128.00	66,798,784.00
Нийтлэг татварын бус орлого	77,956,128.00	66,798,784.00
Түрээсийн орлого	77,956,128.00	66,798,784.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,078,552,800.00	4,344,768,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	4,068,552,800.00	4,344,768,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,068,552,800.00	4,344,768,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,000,000.00	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,000,000.00	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,156,508,928.00	4,411,566,784.00
УРСГАЛ ЗАРДАЛ	3,776,827,695.16	3,916,570,308.38
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,055,865,344.04	4,233,240,844.73
ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,776,827,695.16	3,916,570,308.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,363,961,395.16	3,439,139,808.38
Үндсэн цалин	1,635,629,095.16	1,871,823,608.38
Нэмэгдэл	1,144,502,900.00	926,086,800.00
Унаа хоолны хөнгөлөлт	209,229,400.00	209,229,400.00
Урамшуулал	374,600,000.00	432,000,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	412,866,300.00	477,430,500.00
Тэтгэврийн даатгал	412,866,300.00	351,969,600.00
Тэтгэмжийн даатгал	-	31,365,200.00
ҮОМШӨ-ний даатгал	-	25,092,200.00
Ажилгүйдлийн даатгал	-	6,273,000.00
Эрүүл мэндийн даатгал	-	62,730,500.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,165,709.27	58,265,357.90
Гэрэл, цахилгаан	63,669,281.00	34,694,773.00
Түлш, халаалт	14,572,381.86	20,308,714.89
Цэвэр, бохир ус	3,924,046.41	3,261,870.01
Хангамж, бараа материалын зардал	40,175,853.26	49,358,888.84
Бичиг хэрэг	25,191,320.00	19,728,600.00
Тээвэр, шатахуун	9,208,000.00	8,375,000.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,793,563.26	2,916,123.84
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	811,370.00	731,100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,171,600.00	17,608,065.00
Эд хогшил, урсгал засварын зардал	34,408,973.00	80,801,500.00
Багаж, техник, хэрэгсэл	4,865,500.00	10,681,600.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	807,821.00	12,084,600.00
Урсгал засвар	28,735,652.00	58,035,300.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,682,613.35	103,247,666.88
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,823,670.35	77,949,999.73
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	-
Даатгалын үйлчилгээ	2,014,168.00	2,014,168.00
Тээврийн хэрэгслийн татвар	273,575.00	309,200.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	101,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,698,700.00	11,099,999.15
Газрын төлбөр	591,800.00	591,800.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41,192,700.00	11,181,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	16,604,500.00	24,997,122.73
Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,604,500.00	14,997,122.73
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,643,583.96	178,325,939.27
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,256,747.36	156,656,834.47
Төвлөрүүлэх шилжүүлэг	77,256,747.36	156,656,834.47
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,386,836.60	21,669,104.80
Төвлөрүүлэх шилжүүлэг	23,386,836.60	21,669,104.80
МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,950,382,690.43	9,801,809,271.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-892,144,541.05	-892,144,541.05
2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,058,238,149.38	8,909,664,730.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-1,625,712,706.95	-1,625,712,706.95
2020 оны 12 сарын 31-р үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	432,525,442.43	7,283,952,023.66

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,406,768,000.00	4,233,240,844.73	173,527,155.27	96.1
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,406,768,000.00	4,233,240,844.73	173,527,155.27	96.1
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,406,768,000.00	4,233,240,844.73	173,527,155.27	96.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,814,900.00	316,670,536.35	44,144,363.65	87.8
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	3,568,522,600.00	3,439,139,808.38	129,382,791.62	96.4
Үндсэн цалин	2,001,206,400.00	1,871,823,608.38	129,382,791.62	93.5
Нэмэгдэл цалин	926,086,800.00	926,086,800.00	0.00	100.0
Унаа хоолны нэмэгдэл	209,229,400.00	209,229,400.00	0.00	100.0
Урамшуулал	432,000,000.00	432,000,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	477,430,500.00	477,430,500.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	351,969,600.00	351,969,600.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	31,365,200.00	31,365,200.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	25,092,200.00	25,092,200.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	6,273,000.00	6,273,000.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	62,730,500.00	62,730,500.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,248,000.00	58,265,357.90	39,982,642.10	59.3
Гэрэл, цахилгаан	66,400,000.00	34,694,773.00	31,705,227.00	52.3
Түлш, халаалт	27,694,400.00	20,308,714.89	7,385,685.11	73.3
Цэвэр, бохир ус	4,153,600.00	3,261,870.01	891,729.99	78.5
Хангамж, бараа материалын зардал	50,035,100.00	49,358,888.84	676,211.16	98.7
Бичиг хэрэг	19,730,000.00	19,728,600.00	1,400.00	100.0
Тээвэр, шатахуун	8,375,500.00	8,375,000.00	500.00	100.0
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	3,589,500.00	2,916,123.84	673,376.16	81.2
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	731,100.00	731,100.00	0.00	100.0
БҮТЭЗүйлс	17,609,000.00	17,608,065.00	935.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	80,801,500.00	80,801,500.00	0.00	100.0
Багаж,техник хэрэгсэл	10,681,600.00	10,681,600.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,084,600.00	12,084,600.00	0.00	100.0
Урсгал засвар	58,035,300.00	58,035,300.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	106,730,300.00	103,247,666.88	3,482,633.12	96.7
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,150,000.00	77,949,999.73	200,000.27	99.7
Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	3,000,000.00	0.00	3,000,000.00	0.0
Даатгалын үйлчилгээ	2,258,000.00	2,014,168.00	243,832.00	89.2
Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	309,200.00	300.00	99.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	101,500.00	38,500.00	72.5
Мэдээлэл,технологийн үйлчилгээ	11,100,000.00	11,099,999.15	0.85	100.0
Газрын төлбөр	591,800.00	591,800.00	0.00	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	11,181,000.00	11,181,000.00	0.00	100.0

Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	24,997,122.73	2,877.27	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	14,997,122.73	2,877.27	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,406,768,000.00	4,254,909,949.53	151,858,050.47	96.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	66,798,784.00	-66,798,784.00	0.0
Төрийн өмч түрээслүүсний орлого	0.00	66,798,784.00	-66,798,784.00	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,406,768,000.00	4,188,111,165.53	218,656,834.47	95.0
Улсын төсвөөс санхүүжих	4,406,768,000.00	4,188,111,165.53	218,656,834.47	95.0

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Отгонсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд орон тооны хэтрэлтийн талаар, гэрээ ажил үйлчилгээний талаар, автомашины засвар үйлчилгээний талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 01/02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Улаанбаатар хот дахь гаалийн газар нь “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино” гэсэн ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд стратеги зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн үндсийг гадаад худалдааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох;
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож байгууллагын үйл ажиллагааны бүх шатанд үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Хилийн боомтын болон гүний гаалийн байгууллагын дэд бүтэц, үйл ажиллагааг сайжруулах, төрийн байгууллага хоорондын болон гааль-бизнесийн түншлэл, гаалийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гаалийн мэдээллийн санг боловсронгуй болгох, хууль бус худалдаатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай дүрэм журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох, гаалийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох, тандалт судалгаа явуулах чадавхийг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- Гаалийн лабораторийг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх, албаны эрэлч нохойн үйл ажиллагааг менежментийн шинэ түвшинд хүргэх,
- Улсын төсвийн орлого бүрдүүлэх эрх зүйн акт, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, татвар ногдуулалт, барагдуулалт, төлөлтийг шударга, үр ашигтай, үр дүнтэй болгох;
- Гаалийн байгууллагын үйлчилгээ, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх, хүний нөөцийн цогц бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, санхүү, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, ДХБ болон ДГБ байгууллагаас

боловсруулсан бодлогын баримт бичгийг орчуулж, үндэсний хууль тогтоомжид тусгах, гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны батлагдсан зардлын төсвийн 4,371,768.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 87,435.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,625,712.7 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар буурсан нь хуримтлагдсан элэгдлээс шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	149,613.7	191,824.3	42,210.6
Үндсэн хөрөнгө	8,760,051.0	7,092,127.8	-1,667,923.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,909,664.7</b>	<b>7,283,952.0</b>	<b>-1,625,712.7</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,849,976.4	6,849,976.4	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,909,664.7</b>	<b>7,283,952.0</b>	<b>-1,625,712.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 191,824.3 мянган төгрөг болж 42,210.6 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 2,329.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 37,310.0 мянган төгрөг, тайлант онд худалдан авсан бараа материал зарцуулаагүй үлдэгдэл 3,545.1 мянган төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,092,127.8 мянган төгрөг болж 1,667,923.2 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь

урсгал төсвийн худалдан авалтаар 9,300.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 234,462.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 45,311.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,245,539.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,245,539.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 838,771.1 мянган төгрөгөөр бууруулж 4,406,768.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн захирагч төсвийн төслийг бодитой төлөвлөдөггүй гэж үзэхээр байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 44 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,406,768.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,344,768.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 62,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,188,111.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 66,798.7 мянган төгрөг, нийт 4,254,909.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,233,240.8 мянган төгрөгийг зарцуулж 21,669.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,233,240.8 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 39,982.6 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 129,382.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Гаалийн ерөнхий газраас 2020 онд тус гаалийн газрын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 1,883,630,629.9 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,801,292,261.0 мянган төгрөг буюу 82,338,368.9 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

Д/д	Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Татвар	1,880,749,679.9	1,797,940,996.4	-82,808,683.5
2	Хураамж	1,670,220.0	1,787,816.2	117,596.2
3	Өөрийн орлого	1,210,730.0	1,563,448.4	352,718.4
	Нийт	1,883,630,629.9	1,801,292,261.0	-82,338,368.9

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.



### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		1		50.0
Нийт дүн	1		1		1		

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,210.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,210.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан орон тоо, гүйцэтгэлийн талаар авч үзэх.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1. Бүтэц орон тоотой холбоотой асуудал*

###### *1.1. Илрүүлэлт:*

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тоот тушаалаар "Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын 2 дугаар хавсралтаар Улаанбаатар хот дахь гаалийн газрыг 189 орон тоотой байхаар баталсан. Тайлант онд тус гаалийн газар нь батлагдсан төсөвт орон тоог 20-оор хэтрүүлсэн байна.

###### *1.2. Эрсдэл:*

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

###### *1.3. Өгсөн зөвлөмж:*

*Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тоот тушаалд заасан батлагдсан бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажиллах.*

###### *1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### *2. Зардлын данстай холбоотой асуудал*

###### *2.1. Илрүүлэлт:*

Автомашинь засварт нийт 2,044.3 мянган төгрөг зарцуулахдаа агрегат засвар, гүйлтийн норм хангасан эсэх талаар техник хяналтын акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтад заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### *2.2. Эрсдэл:*

Үнэн зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах, ашиглан үүсэх,

###### *2.3. Өгсөн зөвлөмж:*

Автомашинь засвар үйлчилгээ хийхдээ техник хяналтын акт үйлдэж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтыг мөрдөж ажиллах.

###### *2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### *3. Зардлын данстай холбоотой асуудал*

#### *3.1. Илрүүлэлт:*

Тольтын гол ХХК-тай хийсэн хамгаалалтын гэрээнд заасан үнийн дүнгээс 664.0 мянган төгрөг дутуу, Түшиг богд хан ХХК-тай 1,502.6 мянган төгрөгийн гэрээ хийсэн ч уг гэрээг дүгнэж акт тэмдэглэл үйлдээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

#### *3.2. Эрсдэл:*

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах

#### *3.3. Өгсөн зөвлөмж:*

Аливаа ажил үйлчилгээний гэрээг дүгнэж акт тэмдэглэл үйлдэж, баталгаажуулж байх.

#### *3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Улаанбаатар хот дахь гаалийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			САГ-2021/35/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Улаанбаатар хот дахь гаалийн гзар</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тоот тушаалаар "Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын 2 дугаар хавсралтаар Улаанбаатар хот дахь гаалийн газрыг 189 орон тоотой байхаар баталсан. Тайлант онд тус гаалийн газар нь батлагдсан төсөвт орон тоог 20-оор хэтрүүлсэн байна.	-	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Отгонсүх
2	Автомашинь засварт нийт 2,044.3 мянган төгрөг зарцуулсан нь холбогдох агрегат засвар, гүйлтийн норм болсон эсэх талаар техник хяналтын акт үйлдээгүй байна.	2,044.3	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Д.Гантөмөр
3	Тольтын гол ХХК-тай хийсэн хамгаалалтын гэрээнд заасан үнийн дүнгээс 664.0 мянган төгрөг дутуу, Түшиг богд хан ХХК-тай 1,502.6 мянган төгрөгийн гэрээ хийсэн ч уг гэрээг дүгнэж акт тэмдэглэл үйлдээгүй байна.	2,166.6	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Д.Гантөмөр
<b>ДҮН</b>		<b>4,210.9</b>			